

Эдийн засгийн аюулгүй байдал ба боловсруулах үйлдвэрлэлийн уялдаа

Очирсүрэнгийн Баярмаа*

Докторант, bayarmaa.0088@gmail.com

Монгол Улс, Улаанбаатар, Үндэсний батлан хамгаалахын их сургууль

Лувсандоржийн Оюун

Шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, oyunsanlav@gmail.com

Монгол Улс, Улаанбаатар, Монгол Улсын их сургууль

Хураангуй

Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал нь үйлдвэрлэлийн бүтцийн оновчтой байдал, экспортын төрөлжилт болон импортыг орлох чадамжаас ихээхэн хамаардаг. Гэвч байгалийн баялаг арвин ч уул уурхайн түүхий эдийн экспортоос өндөр хамааралтай, хүнсний болон өргөн хэрэглээний бүтээгдэхүүний импортоос улам бүр хараат болж буй нь эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Энэхүү өгүүлэлд эмпирик өгөгдөлд тулгуурлан сүү, мах, хиам зэрэг хүнсний боловсруулах салбарын үйлдвэрлэл, импорт, экспортын хүчин чадлын ашиглалтыг шинжилж, эдийн засгийн тогтвортой байдалд үзүүлэх нөлөөг тайлбарлав. Судалгааны үр дүнгээр: (1) сүүний үйлдвэрлэл тогтворгүй бөгөөд импортын хараат байдал нэмэгдэж буй; (2) махны экспорт өндөр боловч голдуу түүхий хэлбэртэй тул дотоодод нэмүү өртөг үлдэхгүй байгаа; (3) хиамны үйлдвэрлэл өссөн ч экспортын хэмжээ үлэмж бага байгаа нь тогтоогдов. Эдгээр үр дүн нь “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” (2010), “Алсын хараа–2050”, “Хүнсний хангамж, аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр” (2020-2030) зэрэг бодлогын баримт бичгийн зорилгод нийцүүлэн боловсруулах үйлдвэрлэлийн бүрэн хүчин чадлыг ашиглаж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг дэмжих шаардлагатайг харуулж байна.

Түлхүүр үг: Экспорт, импорт, эдийн засгийн эмзэг байдал, боловсруулах үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн бодлого

Оршил

Монгол Улсын хувьд экспортын 85 орчим хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлж байгаа нь гадаад зах зээлийн эрсдэлд хэт өртөмтгий болгож, дотоод тогтвортой байдлыг сулруулж байна. Нөгөөтгээгүүр, жил бүр 10–12 сая.тн хөдөө аж ахуйн түүхий эд (мах, сүү, ноос, ноолуур, арьс шир, үр тариа, жимс, ногоо)-ийг үйлдвэрлэж байгаа хэдий ч боловсруулалтын түвшин хангалтгүй, үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалт бага байна. Үүний үр дүнд өргөн хэрэглээний бүтээгдэхүүний ихээхэн хэсгийг импортын бүтээгдэхүүнээр хангаж, валютын гадагшлах урсгал нэмэгдэж, эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлжээ.

* Холбоо барих зохиогч

Аюулгүй байдал гэдэг ойлголт нь зөвхөн улс төр, батлан хамгаалалтын үзэл баримтлалаар хязгаарлагдахгүй. Харин нийгэм, эдийн засгийн суурь тогтолцоотой салшгүй холбоотой. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3 дугаар бүлэгт эдийн засгийн аюулгүй байдлыг тодорхойлохдоо: “Хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой эрдэс баялаг, хүнс, хөдөө аж ахуй, эрчим хүч, зам, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, санхүүгийн салбарыг олон улс, Европын Холбооны стандартад нийцүүлэн хөгжүүлнэ”, мөн “Цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна” (Монгол Улсын Их Хурал, 2010) гэж заасан.

Олон улсын хамтын нийгэмлэгт хүлээн зөвшөөрөгдсөн томъёоллоор эдийн засгийн аюулгүй байдалд “Эдийн засгийн эмзэг байдал” гэсэн ойлголтод илүү ач холбогдол үзүүлж байдаг. Улмаар “Эмзэг байдал нь сөргөөр нөлөөлөхүйц цочролд өртөх эрсдэл” гэж илэрхийлжээ. Эмзэг байдлын ерөнхий тодорхойлолтын хүрээнд эдийн засгийн эмзэг байдлыг “Эдийн засгийн орчин эрс өөрчлөгдөхөд тухайн орны сөрөг нөлөөлөлд өртөх эрсдэл” (Оюунгэрэл, 2006) гэж тодорхойлсон байна.

Олон улсын түвшинд улс орны эдийн засгийн аюулгүй байдлыг “Эдийн засгийн эмзэг байдал” гэсэн индексээр хэмждэг бөгөөд тухайн улсын экспортын төвлөрөл, экспортын орлогын хэлбэлзэл, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн савлагаа гэх мэт олон үзүүлэлтээр үнэлэгддэг (Нэгдсэн Үндэстний Байгууллагын Худалдаа, Хөгжлийн Бага Хурал (UNCTAD), 2021).

Монгол Улс НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага (UNIDO)-ын 2025 оны тайланд “Дунд орлоготой, аж үйлдвэржиж буй эдийн засагтай” ангилалд хамаарч байна. UNIDO-гийн ангиллын дагуу дэлхийн улс орныг хоёр үндсэн бүлэгт хуваадаг аж. Үүнд: Аж үйлдвэржсэн эдийн засагтай 64, аж үйлдвэржиж буй эдийн засагтай 148 орон тус тус багтдаг. Өндөр орлоготой аж үйлдвэржсэн эдийн засагтай орнуудын нэг хүнд ногдох боловсруулах үйлдвэрлэлийн нэмэгдэл өртөг дунджаар 5559 ам.доллар байгаа бол бага орлоготой эдийн засагтай орнуудад энэ үзүүлэлт ердөө 67 ам.доллар байна. Үүнээс харахад өндөр болон дунд орлоготой аж үйлдвэржсэн орнууд нь үйлдвэрлэлд ажиллагсдын эзлэх хувь болон дунд, өндөр технологийн экспортын хэмжээгээр илт давуу байгаа юм. Харин аж үйлдвэржилтийн шатандаа буй орнууд түүний дотор Монгол Улс эдгээр үзүүлэлтээр хоцрогдож байгаа нь үйлдвэрлэлийн бүтцийн сул талыг харуулж байна. Энэхүү өгүүлэлд 2015–2024 оны хоорондох улсын статистик, Гаалийн ерөнхий газар (ГЕГ), Монголбанк болон UNCTAD, UNIDO, FAO зэрэг олон улсын байгууллагын эх сурвалжийг ашиглан судалгаа хийсэн болно.

Судалгаанд нийт үйлдвэрлэлийг тодорхойлохдоо нэг хүнд ногдох бүтээгдэхүүнийг тухайн жилийн хүн амын дундаж тоонд үржүүлж тооцсон. Мөн экспорт, импортын харьцуулалтыг жил бүрийн бүтээгдэхүүн, бүлгийн хэмжээг тэнцлээр нь үнэлж, салбарын суурь чадамж болон бодит ашиглалтыг харьцуулан хүчин чадлын ашиглалтыг тодорхойлохыг зорив. Судалгааны хамрах хүрээг

хүнсний аюулгүй байдал, нэмүү өртгийн сүлжээнд стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн болох сүү, мах, хиам зэрэгт төвлөрлөө.

Онолын үндэс ба судлагдсан байдал

Эдийн засгийн аюулгүй байдлыг тайлбарлахад хэд хэдэн онолын хандлага холбогдоно. Неореализм (Waltz, 1979; Gilpin, 2001) улс орны эдийн засгийн чадавх, дотоод үйлдвэрлэл нь тусгаар тогтнолын баталгаа хэмээн үздэг. Структурализм (Prebisch, 1950) түүхий эдэд суурилсан экспортын бүтэц нь эмзэг байдлыг өсгөж, харин боловсруулах үйлдвэрлэлийн хөгжил нь дархлааг бэхжүүлнэ гэж нотолдог. Институцийн эдийн засаг (North, 1990) үйлдвэрлэлийн тогтвортой хөгжилд эрх зүй, бодлого, төр-хувийн хэвшлийн түншлэл, зах зээлийн институтийн чанарыг онцолдог. Нэмүү өртгийн онол (Porter, 1985) нь үйлдвэрлэлийн шат ахих тусам дотоодод үлдэх өгөөж өсөж, тогтвортой байдал нэмэгддэг гэж тайлбарладаг.

Монгол Улсын эдийн засгийн эмзэг байдлын талаар олон улсын байгууллагуудын хийсэн судалгааны үр дүн нь дээр дурдсан онолуудтай нийцэж байна. НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага (UNIDO)-ын 2025 оны тайлангаар Монгол Улс “Дунд орлоготой, аж үйлдвэржилтийн шатандаа буй” улсын ангилалд орсон. Энэ нь нэг хүнд ногдох боловсруулах үйлдвэрлэлийн нэмэгдэл өртөг ердөө 346 ам.доллар, үйлдвэрлэлд ажиллагсдын эзлэх хувь 9.5 хувь, дунд ба өндөр технологийн экспорт 16 ам.доллар байгааг тайланд дурдсан. Эдгээр үзүүлэлт нь дэлхийн медианаас доогуур байгаа нь эдийн засгийн бүтцийн эмзэг байдлыг баталгаажуулж байна.

Хүснэгт 1. UNIDO-ийн ангилал дахь Монгол Улсын үзүүлэлтүүд (2025)

Улсын код	498	496	504	492	500	508
Улсын нэр	Молдав	Монгол	Марокко	Монако	Монтсеррат	Мозамбик
Орлогын түвшин	Дунд	Дунд	Дунд	Өндөр	Өндөр	Бага
Нэг хүнд ногдох боловсруулах үйлдвэрлэлийн нэмэгдэл өртөг (2015 оны тогтмол ам.доллар)	306	346	547	6267	557	45
Үйлдвэрлэлд ажиллагсдын хамгийн их эзлэх хувь (%)	15.2	9.5	12.8	3.6	8.2	4.8
Хамгийн их хувь хүрсэн он (ажиллах хүч)	1991	2023	2008	2006	1996	2023

ДНБ-д эзлэх боловсруулах үйлдвэрлэлийн хамгийн их хувь	33.1	19.5	19.3	6.9	8.2	16.7
Хамгийн их хувь хүрсэн он (ДНБ)	1993	1992	1995	2006	1996	1992
Дунд ба өндөр технологийн экспорт (1 хүнд ногдох, ам.доллар)	272	16	477	4797	551	5
UNIDO-ийн ангилал	Дунд орлоготой аж үйлдвэржиж буй		Өндөр орлоготой аж үйлдвэржсэн		Бага орлоготой	

Эх сурвалж: НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага. (2025). 2024 оны жилийн тайлан ¹

Мөн “Дэлхийн банк болон Олон улсын Хүнс, хөдөө аж ахуйн бодлогын судалгааны хүрээлэнгээс (IFPRI) 2022 онд гаргасан “Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуйн системийн ногоон шилжилтийн тайлан”-д сүү, махны үйлдвэрлэлд эдийн засгийн төрөлжилт, ядуурлыг бууруулахад чухал ч хүчин чадлын ашиглалт дутмаг, бэлчээрийн даац хэтрэлт, хөрөнгө оруулалтын дутагдал нь үйлдвэрлэлийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж буйг онцолжээ. НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)-ын “Монгол Улсын махны дотоодын болон экспортын үнэ цэнийн сүлжээний судалгаа”-ны 2021 оны тайланд Монголын махны экспортын бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээ олон бэрхшээлтэй (малын эрүүл мэнд, ариун цэврийн стандарт, нядалгааны технологийн хоцрогдол, дэд бүтцийн дутагдал) тулгарч байгаа нь нэмүү өртөг шингэсэн экспортын хөгжлийг хязгаарлаж буйг тодорхойлсон (Оюунгэрэл, 2006). НҮБ-ын тооцоогоор 1999-2001 онд Монгол Улсын эдийн засгийн эмзэг байдлын индекс (ЭЗЭБИ) 48.1 байсан нь дэлхийн 64 нэн буурай улсын дунд 19-т эрэмбэлэгдэж байв.

Сүүний үйлдвэрлэл


Нэг хүнд ногдох бүтээгдэхүүн 2015–2024 онд ойролцоогоор 20.9–51.6 литр, нийт үйлдвэрлэл 72.8-171.7 сая литрийн хооронд савласан. Импорт тогтмол өсөж, 2015 онд 197 мянган литр орчим байсан бол 2024 онд ойролцоогоор 343 мянган литр хүрч, экспорт бараг үгүй.

Улсын хэмжээнд бүртгэлтэй 161 сүүний үйлдвэр байгаа ч хүчин чадлын ашиглалт дунджаар 44 хувь; улирлын савлагаа, түүхий эдийн тогтмол нийлүүлэлт,

¹ Нэг хүнд ногдох боловсруулах үйлдвэрийн нэмэгдэл өртөг (MVA), үйлдвэрлэлд ажиллагсдын эзлэхувь, дунд ба өндөр технологийн экспортын нэг хүнд ногдох хэмжээ дэлхийн миддиан (median) босгоос доогуур байгааг илтгэнэ. (Миддиан гэдэг нь өгөгдлийг эрэмбэлэхэд дундах байрлалын утга; тэгш тохиолдолд дундах хоёр утгын дунджийг авна. UNIDO эдгээр гурван үзүүлэлтийн дэлхийн миддианыг ангиллын босго болгон ашигладаг.)

хүйтэн хэлхээний дэд бүтцийн хязгаарлалтууд гол шалтгаан болж байна (Дэлхийн Банк, 2022). Ингэснээр дотоодын чадавх тогтвортой бус, импортын хараат байдал нэмэгдэж буй нь эдийн засгийн эмзэг байдлыг өсгөдөг.

График 1. Шингэн сүүний экспорт-импортын хэмжээ (2014-2025)




Эх сурвалж: (ГЕГ, 2025)

Махны үйлдвэрлэл

Нийт үйлдвэрлэл 2015 онд ойролцоогоор 15.1 сая кг байсан бөгөөд 2024 онд 51.4 сая кг орчимд хүрч, гурав дахин өссөн байна. Экспорт нь импортын хэмжээнээс олон дахин их боловч голдуу түүхий мах хэлбэрээр гардаг тул нэмүү өртгийн ихэнх нь гадаадад үлддэг. Бүртгэлтэй, мах боловсруулах 120 үйлдвэр өдөрт ойролцоогоор 36320 бог мал, 7830 орчим бод мал нядлах суурь чадамжтай ч бодит ашиглалт 10 хувиас доош түвшинд хадгалагдаж байна. Малын эрүүл мэнд, ариун цэврийн стандарт, нядалгааны технологи, хүйтэн хэлхээ, логистик зэрэг “хүзүүний бөглөрөл”²- үүд экспортыг нэмүү өртөгтэй хэлбэрт шилжүүлэхийг хязгаарладаг (Нэгдсэн Үндэстний Байгууллагын Худалдаа, Хөгжлийн Бага Хурал (UNCTAD), 2021).


² “Хүзүүний бөглөрөл” (*bottleneck*) нь системийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн процесс, эсвэл эдийн засгийн бүтцэд нийт үйл явцын хүчин чадлыг хязгаарлаж буй хамгийн сул, хамгийн чадавх багатай хэсгийг хэлнэ. Өөрөөр хэлбэл: Нийт бүтээмж, үр ашиг тухайн хязгаарлагч хүчин зүйлээс шалтгаалан бүрэн дүүрэн хэрэгжиж чаддаггүйг илэрхийлдэг (Goldratt, 1984)

График 2. Малын махны экспорт-импортын хэмжээ (2015-2024)



Үйлдвэрлэл 2015 онд ойролцоогоор 3.8 сая кг, 2024 онд 10.2 сая кг орчим болж өссөн ч экспорт маш бага, импортын хэмжээ харьцангуй өндөр хэвээр. Энэ нь технологийн шинэчлэл, брэнд-маркетинг, чанарын стандарт, түүхий эдийн жигд нийлүүлэлтийн асуудлыг илтгэнэ. Нэмүү өртөг шингэсэн салбар боловч дотоодын зах зээлд “хэмжээний эдийн засаг”³ бүрдээгүй, экспортын зах зээлийн шаардлагыг өргөн хүрээнд хангах чадавх сул байна.

График 3. Хиам, хиаман бүтээгдэхүүний экспорт-импортын хэмжээ (2015-2024)




Эх сурвалж: (ГЕГ, 2025)

³ Хэмжээний эдийн засаг гэдэг нь үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр нэгж бүтээгдэхүүнд ногдох зардал буурах үзэгдлийг хэлнэ. Энэ нь ихэвчлэн томоохон үйлдвэрлэл, бизнесийн нэгжүүдэд ажиглагддаг бөгөөд дараах хүчин зүйлсээс шалтгаалдаг:

- **Үйлдвэрлэлийн үр ашиг:** Томоохон хэмжээний үйлдвэрлэлд тоног төхөөрөмж, технологийг илүү үр ашигтай ашиглах боломжтой болдог.
- **Материалын хэмнэлт:** Их хэмжээгээр худалдан авалт хийх үед материалын зардал буурах магадлалтай.
- **Менежментийн үр ашиг:** Томоохон байгууллагууд менежментийн зардлыг хуваарилах боломжтой байдаг.
- **Сургалтын үр ашиг:** Ажилчид туршлага хуримтлуулж, ажлын бүтээмж нэмэгддэг.

Энэ үзэгдэл нь бизнесийн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, зах зээлд илүү давуу талтай болох нөхцөлийг бүрдүүлдэг. (Даваадорж, Болормаа, & Баттулга, 2007)

График 4. Экспортын бүтэц, хувиар, 1995-2023 он



Эх сурвалж: УСХ.(2023). Эдийн засгийн аюулгүй байдал: 2023 оны тайлан

Дээрх графикаас харахад экспортын бүтцэд 1990-2000 оны хооронд хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүн багагүй хувийг эзэлж байжээ. Гэхдээ уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой сүүлийн 20 жилд үлэмж хэмжээгээр жин дарах болсон нь хүнсний салбарт хөрөнгө оруулалт бага байгааг илэрхийлж байгаа юм.

Монгол Улсын гадаад худалдаа цөөн улсын зах зээлд хэт төвлөрсөн хэвээр байна. Тухайлбал: 2023 оны байдлаар нийт бараа эргэлтийн 72.5 хувийг БНХАУ, 10.2 хувийг ОХУ эзэлж байгаа нь зах зээлийн хамаарлыг тодорхой харуулжээ. БНХАУ-д 2010–2023 онд нийлүүлсэн экспорт дунджаар 86.5 хувь байсан бол уул уурхайн салбарын өсөлт оргилд хүрсэн 2011, 2012 онд энэ үзүүлэлт 92.4 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна (Үндэсний статистикийн хороо, 2023).

Хүнсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын бүтцийг авч үзвэл:

- **28.1 хувь** – ямааны угаасан болон самнасан ноолуур;
- **10.9 хувь** – лаазалсан махан бүтээгдэхүүн;
- **9.8 хувь** – адууны мах;
- **9.0 хувь** – самар;
- **42.2 хувь** – бусад бараа.

Хүснэгт 2. Уул уурхайн бус барааны экспорт

Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ		Өмнөх онтой харьцуулсан хувь	Үнийн дүн		Өмнөх онтой харьцуулсан хувь
		2022	2023		2022	2023	
		сая ам.доллар					
Нийт	-	-	-	-	859.9	1278.4	48.7
Ямааны угаасан ноолуур	мян.тн	6.4	5.4	-15.6	308.4	264	-14.4
Ямааны самнасан ноолуур	тн	857	1001.1	16.8	93.1	95.9	3
Бусад самар	мян.тн	6.8	8.5	25.3	84.6	115.4	36.5
Тунгаасан зэс ба хайлш	мян.тн	10	12.5	25.3	82.6	102.5	24.2
Адууны мах	мян.тн	6.9	32.9	4.81	21.1	125.5	5.91
Агаарын тээврийн хэрэгсэл	ш	5	5	-	20	44.7	2.21
Свитер, пуловер, джемпер, жилет болон бусад сүлжмэл гадуур цамц	мян.ш	343.6	298.1	-13.2	18.6	17	-8.8
Лаазалсан махан бүтээгдэхүүн	мян.тн	5	33	6.61	17.4	139.5	8.01
Бог малын өлөн гэдэс	тн	632.4	517.3	-18.2	15.9	11.2	-29.4
Сэмлээгүй эсвэл самнаагүй хонины ноос	мян.тн	17.7	13.3	-24.8	14.8	14	-5.8
Хонь, ямааны мах	мян.тн	4.7	12.7	2.71	14.4	44.2	3.11
Рапс	мян.тн	23.4	73.5	3.11	14.4	44.8	3.11
Бусад	-	-	-	-	154.6	259.8	68

Эх сурвалж: (Үндэсний статистикийн хороо, 2023)

Дээрхээс харахад хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүн буюу аж үйлдвэрийн боловсруулсан бүтээгдэхүүний экспорт маш бага байна. Энэ нь эдийн засгийн эмзэг байдлыг өсгөж, олон улсад өрсөлдөх чадварыг багасгаж, түүхий эдийн үнийн хэлбэлзэлд хэт хамааралтай болгож байгаа юм. Ийм нөхцөл байдал нь Үндэсний

аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.5.1-г заасан “Үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах” зорилт хэрэгжихгүй байгааг тодорхой харуулна.

Үйлдвэрийн хүчин чадлын үнэлгээ ба бодлогын орчин

Монгол Улсад бүртгэлтэй 161 сүүний үйлдвэр хүчин чадлынхаа ердөө 44 хувийг ашиглаж байгаа нь тогтвортой бус байдлын үндсэн шалтгаан болж байна (Дэлхийн Банк, 2022). Мах боловсруулах 120 үйлдвэр өдөрт 36 мянга гаруй бог мал, 7800 орчим бод мал нядлах суурь чадамжтай ч хүчин чадлынхаа 10 хувиас бага хувийг ашиглаж байна (Нэгдсэн Үндэстний Байгууллагын Худалдаа, Хөгжлийн Бага Хурал (UNCTAD), 2021). Өөрөөр хэлбэл: Монгол Улсад боловсруулах үйлдвэрлэлийн суурь чадамж тодорхой хэмжээнд бүрдсэн боловч бодит ашиглалт хангалтгүй байна.

Сүүний импорт нэмэгдэж буй нь хүйтэн хэлхээний⁴ дэд бүтцийн сул байдал, улирлын савлагаатай холбоотой. Махны экспортын ихэнх нь түүхий хэлбэртэй тул нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл бага байна. Хиамны үйлдвэрлэл нэмүү өртөг өндөртэй ч нийт хэмжээ бага, экспорт сул хэвээр байна.

Нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн хөгжихгүй байгаа нь эдийн засгийн эмзэг байдлын суурь шалтгаан болдог. Монгол Улсын эдийн засгийн бүтцэд хөдөө аж ахуй стратегийн байр суурь эзэлдэг. Хүн амын хүнсний хэрэгцээний ихэнхийг мал аж ахуйгаас хангаж байгаа нь эдийн засгийн дотоод аюулгүй байдалд шууд нөлөө үзүүлдэг. Гэвч сүүлийн жилүүдэд малын тоо толгой өссөн ч боловсруулах үйлдвэрлэл сул, нэмүү өртөг шингээх чадвар хязгаарлагдмал байгаа нь эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд (Монгол Улсын Их Хурал, 2010) эдийн засгийн аюулгүй байдлыг “*Үндэсний баялгаа зохистой ашиглаж, дотоодын үйлдвэрлэлээ хөгжүүлэн, иргэдийнхээ хэрэгцээг хангах, тогтвортой өсөлтийг хангах, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай байх*”-тай шууд холбоотой гэж тодорхойлсон байдаг. Мөн хүнсний аюулгүй байдлын хүрээнд “*Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, хүнсний бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, стратегийн хүнсний бүтээгдэхүүний импортыг бууруулах замаар эдийн засгийн аюулгүй байдлыг хангана*” гэж заасан нь эдийн засгийн дархлаа, тогтвортой байдалд хүнсний үйлдвэрлэлийн стратегийн үүргийг илэрхийлж байна.

Үүнтэй уялдуулан Алсын хараа-2050 (Монгол Улсын Их Хурал, 2020) хөгжлийн бодлогын баримт бичигт эдийн засгийн төрөлжилт, үндэсний үйлдвэрлэлийн чадавхыг нэмэгдүүлэх, уул уурхайгаас хэт хамаарлыг бууруулах, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зорилтуудыг тодорхой зааж өгсөн. Тухайлбал: “*Хүнсний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, нэмүү өртөг шингэсэн экспортын*

⁴ Хүйтэн хэлхээ гэдэг нь хүнсний бүтээгдэхүүнийг (мах, сүү, ногоо, жимс г.м.) үйлдвэрлэлээс хэрэглэгчид хүргэх бүх шатанд шаардлагатай тогтмол температурын нөхцөлийг хадгалж, чанар, аюулгүй байдлыг хангах логистикийн системийг хэлнэ. Энэ нь хадгалалт, тээвэрлэлт, түгээлтийн бүх үйл явцыг хамардаг (International Institute of Refrigeration, 2021)

бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ” гэж онцолсон нь эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах стратегийн бодлогоор ойлгогдоно.

Хүнсний хангамж, аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр (Монгол Улсын Засгийн газар, 2020) нь стратегийн баримт бичгийн хувьд чухал ач холбогдолтой. Тус хөтөлбөрт *“Хүн амын хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах, хүнсний импортыг бууруулах, стратегийн хүнсний бүтээгдэхүүний тогтвортой үйлдвэрлэл, нөөцийг бүрдүүлэх замаар хүнсний аюулгүй байдлыг хангах”* зорилтыг тодорхой заажээ. Энэ хүрээнд сүүний боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлэх, махны экспортыг нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүнд чиглүүлэх, хүнсний стандартыг олон улсын түвшинд нийцүүлэх шаардлагыг хөтөлбөр тодорхойлж байна. Мөн Аж үйлдвэрийн IV хувьсгал ба инновацын бодлогын хүрээнд *“Импортыг орлох болон экспортын чиг баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь эдийн засгийн дархлааг бэхжүүлэх стратегийн зорилго мөн”* гэж тодорхойлсон нь эдийн засгийн аюулгүй байдлын бодлогын чиг хандлагатай шууд уялдаж байна.

Дүгнэлт

1. Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал боловсруулах үйлдвэрлэлийн хөгжилтэй шууд уялдаатай байна.
2. Сүүнд импортын хараат байдал өссөн, маханд түүхий хэлбэр давамгайлж, нэмүү өртөг гадагш алдагдаж, хиамны үйлдвэрлэл өссөн ч экспорт сул байна.
3. Боловсруулах үйлдвэрлэлийн суурь чадамж бий ч ашиглалт сул, институц, стандарт, дэд бүтэц, санхүүжилт, хүний нөөцийн тогтолцооны бөглөрөл байна.

Санал

1. **Сүү.** Хүйтэн хэлхээний дэд бүтэц, түүхий сүүний худалдан авалтын стандарт-схем нэвтрүүлэх; улирлын савлагааг бууруулахад зориулсан сүүний нунтаг/концентратын технологи, эргэлтийн санхүүжилт.
2. **Мах.** Экспортын стандартыг бүрэн мөрдүүлэх (НАССР, Halal)⁵, нэмүү өртөгтэй бүтээгдэхүүн (тасалгааны бэлэн мах, орц найрлагатай махан бүтээгдэхүүн, консерв) рүү шилжих урамшууллын багц; эрх зүйн орчныг экспортын гэрчилгээжүүлэлтийн нэг цонх загвартай холбох. Эдгээр стандартчиллын баримт бичгүүд нь Монгол Улсын дотоод зохицуулалт, салбарын шаардлагыг тодорхойлох албан баримтууд бөгөөд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гэрчилгээ авах, экспортод бэлтгэх үед чухал үүрэгтэй.
3. **Хиам.** Технологийн шинэчлэл, брэнд ба маркетинг, сав баглаа боодлын инновац; дотоодын нийлүүлэлтийн тогтвортой гэрээт систем.

⁵ НАССР-ийн хувьд, Монгол Улсад хүний эрүүл мэнд, хүнсний чанар, стандартчилалтай уялдан хэрэглэгдэх “Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоог стандартчлах баримт бичгүүд”

Halal стандартыг Монгол Улсад албан ёсоор “MNS OIC/SMIIC 2:2023 Тохирлын үнэлгээ – Халал” стандарт төсөл хэлбэрээр боловсруулж байгаа бөгөөд энэ стандарт нь бүтээгдэхүүний производц, үйлчилгээнд “Halal байдал” буюу шариагтын шаардлагад нийцсэн байдлыг шалгах, баталгаажуулах журам, үнэлгээний хэм хэмжээ зэрэг заалтыг агуулжээ.

4. **Институц.** Төр-хувийн хэвшлийн түншлэлээр бүсийн агро-индустриаль парк/кластер байгуулж, нийт сүлжээгээр стандарт, аудит, логистикийг шийдэх; санхүүжилтийн мэдлэг-техникийн багц ашиглах.
5. **Үзүүлэлт.** Эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах зорилгоор UNIDO-гийн гурван гол үзүүлэлтийг дэлхийн медиантай тогтмол харьцуулан зорилтот босго тогтоож, жил бүрийн тайлан-хяналтыг нээлттэй болгох.

Эх сурвалжийн жагсаалт

Монгол Улсын Засгийн газар. (2020). *Хүнсний хангамж, аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр (2020–2030)*. Улаанбаатар: Монгол Улсын Засгийн газар.

Монгол Улсын Их Хурал. (2020). *Алсын хараа-2050: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого*. Улаанбаатар: Монгол Улсын Их Хурал.

“Дэлхийн Банк, О. У. (2022). *Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуйн системийн ногоон шилжилт (Green transformation of the Mongolian agri-food system)*. Дэлхийн Банк. doi:<https://doi.org/10.1596/37970>

Gilpin, R. (2001). *Global Political Economy [Дэлхийн улс төрийн эдийн засаг]*. Princeton, NJ: Princeton University Press.

Goldratt, E. M. (1984). *The goal: A process of ongoing improvement*. Croton-on-Hudson NY: North River Press.

International Institute of Refrigeration. (2021). *The role of the cold chain in ensuring food safety and quality (Хүйтэн хэлхээний хүнсний аюулгүй байдал, чанарыг хангахад гүйцэтгэх үүрэг)*. Paris: International Institute of Refrigeration.

North, D. (1990). *Institutions, institutional change and economic performance [Институци, институцийн өөрчлөлт ба эдийн засгийн гүйцэтгэл]*. Cambridge: Cambridge University Press.

Porter, M. (1985). *Competitive advantage [Өрсөлдөөний давуу тал]*. New York: Free Press.

Prebisch, R. (1950). *The economic development of Latin America and its principal problems [Латин Америкийн эдийн засгийн хөгжил ба түүний гол асуудлууд]*. New York: United Nations.

Waltz, K. (1979). *Theory of International Politics [Олон улсын улс төрийн онол]*. Reading, MA: Addison-Wesley.

ГЕГ. (2025 оны 09 01). <https://customs.gov.mn/>. 2015–2024 оны статистик

Даваадорж, Ц., Болормаа, Г., & Баттулга, С. (2007). *Экономиксийн үндэс*. Улаанбаатар: “Содпресс” ХХК.

Дэлхийн Банк. (2022). *Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуйн системийн ногоон шилжилт (Green transformation of the Mongolian agri-food system)*. Дэлхийн Банк: Олон Улсын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Бодлогын Судалгааны Хүрээлэн.

Монгол Улсын Их Хурал. (2010). *Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал*. Улаанбаатар хот: Монгол Улсын Их Хурал (УИХ-ын 48 дугаар тогтоолын хавсралт).

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Худалдаа, Хөгжлийн Бага Хурал (UNCTAD). (2021).

Монгол Улсын махны дотоодын болон экспортын үнэ цэнийн сүлжээний судалгаа. Нэгдсэн Үндэстний Байгууллага.

Оюунгэрэл, Л. (2006). Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд “гуравдагч хөршийн” үүрэг, холбогдол. *Олон улс судлал*, №3.

Үндэсний статистикийн хороо. (2023). *Эдийн засгийн аюулгүй байдал: 2023 оны тайлан*. Улаанбаатар: Үндэсний статистикийн хороо.

Economic Security and the Linkages with Processing Industry

Bayarmaa Ochirsuren

Ph.D., candidate, bayarmaa.0088@gmail.com
Mongolian National Defense University, Ulaanbaatar, Mongolia

Oyun Luvsandorj

Doctor of Science (Sc.D), Professor, oyunsanlav@gmail.com
National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

Abstract

Mongolia's economic security largely depends on the efficiency of its industrial structure, the diversification of exports, and the capacity to substitute imports. Despite its abundant natural resources, the country remains highly dependent on the export of mining raw materials while increasingly reliant on imported foodstuffs and consumer goods, which amplifies economic vulnerability. This article, drawing on empirical data, examines the utilization of production, import, and export capacities in the food processing sectors of milk, meat, and sausages, and explains their implications for economic stability. The findings indicate that: (1) milk production is unstable, with rising import dependence; (2) meat exports are high but mostly in raw form, leaving little added value domestically; and (3) sausage production has grown, yet export volumes remain very limited. These results underscore the need to align with the objectives of key policy documents such as the National Security Concept (2010), Vision–2050, and the National Food Security Program (2020–2030), by fully utilizing the installed capacity of the processing industry and promoting production with higher added value.

Keywords: *Export, Import, Economic vulnerability, Processing Industry, Agricultural policy*

Received: September 10, 2025 | Accepted: September 17, 2025 | Published online: October 13, 2025



© The Author(s) 2025

<http://creativecommons.org/licenses/by/4.0/>